



# BPN байгууллагын эрхэм зорилго

## АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

BPN сангийн эрхэм зорилго нь хөгжиж буй орнуудын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд шаардлагатай мэдлэг чадвар, хэрэгцээт тоног төхөөрөмжийн дэмжлэн үзүүлэн чадавхижуулснаар тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлж, тэдний ажилтнууд, гэр бүл цаашлаад тухайн улс үндэстний таатай ирээдүйг бий болгоход оршино.

Бид хөгжиж буй орнуудын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд компани зөв удирдаж, бизнесээ амжилттай хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг. Ингэснээр бизнес эрхлэгчдийн гэр бүл, тэдний ажилтнуудын сайн сайхан ирээдүйн үндсийг бий болгож, нийгэм, эдийн засагт нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Бидний явуулж буй үйл ажиллагаа нийгэмд ач холбогдол, үр өгөөжтэй байх ёстой. Бидний уриа: “Хэн нэгэнд та загас өгснөөр түүнийг нэг л өдөр хооллоно. Харин загас барих аргыг зааж өгснөөр түүний гэр бүлийг насан туршид нь хооллоно. Тэгвэл загасны үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлснээр түүний ажилтнууд төдийгүй гэр бүлийг нь ч гэсэн хооллоно гэсэн үг юм.”

BPN нь хөтөлбөр хэрэгжиж буй орнууддаа чанарын төдийгүй тоон өсөлтийг бий болгож, санхүүгийн эрсдлийг бууруулахыг зорьдог. Бидний урт хугацааны зорилго бол хөтөлбөр хэрэгжиж буй орнууддаа үйлчилгээ болон сангаараа дамжуулан санхүүгийн хувьд бие даан ажиллах явдал юм.

## БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

**Бидний үйл ажиллагаа ёс зүйн үнэт зүйлүүдэд тулгуурладаг.**

Бидний итгэл үнэмшил бүхий үйл ажиллагаа нь энх тайван байдал, шударга ёс, хангалуун амьдрал төдийгүй тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэгддэг. Бусдыг хайрлаж хүндэтгэн, хүлээцтэй, хөдөлмөрч, хариуцлагатай, нэгдмэл, үнэнч шударга байх нь хувь хүн төдийгүй байгууллагын урт хугацаанд амжилттай оршин тогтнохын үндэс болдог. Бид урт хугацааны, тогтвортой үйл ажиллагааг эрхэмлэж, хувь хүн төдийгүй нийгэмд анхаарлаа хандуулдаг.

**Бид итгэлцлийг бий болгон шударга, ил тод харилцааг эрхэмлэдэг**

Бид гадаад, дотоод бүхий л харилцаандаа няхуур хандаж, шударга байдлыг эрхэмлэдэг. Түүнчлэн хөрөнгө оруулагч, хөтөлбөрийн оролцогч, хэвлэл мэдээлэл болон төрийн байгууллагуудтай харилцан итгэлцлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулж, ажлын таатай орчныг бүрдүүлэхийг эрмэлздэг

**Бид ажиллагсадаа хүндлэн, дэмжлэг үзүүлж, тэдэнд шаардлага тавьдаг.**

Бид ажиллагсадынхаа хувийн зан чанар, соёл, шашин шүтлэгийг хүндэтгэдэг. Ажилтнуудаа мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, зөвлөгөө өгөх, ур чадварыг нь дээшлүүлэх тал дээр анхаардаг. Ажилтан бүр BPN-ийн алсын хараа, үнэт зүйлсийг танин мэдэж, бодол санаа, хийж буй үйлдлээрээ үлгэр дууриал үзүүлж, хариуцлагатай ханддаг. Хүлээсэн





үүрэг даалгавраа цаг ямагт хөдөлмөрч, үнэнч шударгаар гүйцэтгэхийг ажилтнуудаасаа шаарддаг. Бид байгууллагад хувийн ашиг сонирхлын зөрчлөөс үүдсэн хохирол учруулахаас зайлсхийдэг.

**Бид зорилго, зорилтуудаа тодорхойлж, ил тод байлгадаг.**

BPN сангийн зөвлөл гол зорилтууд болон ажлын арга барилаа тодорхойлж, үйл ажиллагааны зорилгыг салбар тус бүрийн удирдлагуудтай хамтран гаргаж, тогтсон хугацаанд хяналт тавьдаг. Бүх ажилтнууд байгууллагынхаа зорилгыг ухамсарлан ажилладаг.

**Бид дэмжиж буй бизнес эрхлэгчдийнхээ адилаар түнш байгууллагуудынхаа нэр хүнд болон эрхийг дээдэлдэг.**

Бид бусадтай зөв харилцахыг эрхэмлэж, бизнес эрхлэгчдийнхээ халдашгүй байдал, соёл, шашин шүтлэгийг хүндэтгэн үздэг. Бид бусдын нэр хүндийг хүндэтгэн, хариуцлагатай байхыг хөтөлбөрийн оролцогчидоосоо хүсдэг. Бизнес эрхлэгчид явуулж буй үйл ажиллагааныхаа өмнө хариуцлага хүлээх чадвар бүхий хуулийн этгээд байна.



**Бид нөөц, эд хөрөнгийг ариг гамтай ашигладаг.**

Ажилтан бүр байгууллагын эд юмс, оюуны өмч, санхүү болон бусад эд хөрөнгийг ариг гамтай ашиглах үүрэгтэй. Байгууллагын эд хөрөнгийг хувьдаа ашиглахыг хориглоно. Бид ажиллагсад болон хөтөлбөрийн оролцогчиддоо байгаль дэлхий, хүрээлэн буй орчиндоо ухамсартай хандахыг зааж сургадаг.

**Бид гадаад, дотоод харилцаандаа шударга хандахыг эрхэмлэдэг.**

Бид бусад байгууллагууд болон хувь хүмүүстэй шударга, ил тод харьцсанаар, байгууллагынхаа нэр хүндийг өндөрт өргөдөг. Ямарваа далд утга санаа агуулсан бэлэг сэлтийг ажилтнууд болоод гуравдагч этгээдэд өгөх, авахаас болгоомжилдог. Бид үйл ажиллагаагаа ил тод, шударгаар төрийн байгууллагуудад тайлагнаж, хөтөлбөрийн оролцогчидоо ч мөн адил үйл ажиллагаагаа ил тод явуулахыг хүсдэг. Бид ядуурлыг дэмжсэн, хөгжилд саад учруулж, хүмүүс хоорондын таагүй харьцааны үндэс болдог авлига хээл хахуулийн бүхий л хэлбэрээс татгалздаг.

